

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Соёл, урлагийн их сургуулийн 2025 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/59/НА-СТА-ТӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: С.Нацагдорж Утас:51-260512 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Э.Бат-Эрдэнэ Утас:51-261628 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:Анализ старт аудит ХХК-ийн захирал Н.Энхтуяа Утас: 99075818 Цахим хаяг: asaudit.mn@gmail.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	14
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	15
3.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	17
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	18
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал.....	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	21
5.3. Зөвлөмж.....	24
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	26
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл	26
6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл	28
6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	29

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТБОНӨХБАУХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчийн үйлдвэрийн газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

СОЁЛ УРЛАГИЙН ИХ СУРГУУЛИЙН
РЕКТОРИЙН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ч.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

2026.03.27 № 06/827
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Соёл урлагийн их сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

ЮНЕСКО-ийн Соёлын биет бус өвийг хамгаалах Монгол бий биелгээг өвлүүлэн уламжлуулж, тогтворжуулах 111.9 сая төгрөгийн төсөвтэй төсөл нь 2022 оноос эхэлж, тайланд онд амжилттай хэрэгжиж дууссан байна.

Засгийн газрын 2024 оны 207 дугаар тогтоолын дагуу Соёл, урлаг судлалын хүрээлэн нь Соёл урлагийн их сургуулийн бүтцээс гарч, улсын төсвөөс санхүүжих байгууллага болсон байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Дээд боловсролын тухай хуулийг үндэслэн тайлант онд хичээлийн байр, дотуур байрны тогтмол зардлын санхүүжилтийг улсын төсвөөс авахаар 455.5 сая төгрөгийг төсөвлөсөн боловч Засгийн газрын 2024 оны 164 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын эзэмшиж, ашиглаж байгаа хөрөнгийн төрийн өмчийн тогтмол зардлыг санхүүжүүлэх журам"-ын шалгуурыг хангаагүй гэсэн үндэслэлээр олгоогүй байна.

Бусад асуудлын хэсэг

Соёл урлагийн их сургууль нь санхүүгийн тайлангаа хуулийн хугацаанаас хоцроож, 2026 оны 3 дугаар сарын 11-нд ирүүлж, аудитын үйл ажиллагаанд хүндрэл учруулсан.

Тус сургуулийн бараа материалд үндсэн хөрөнгийн шинж агуулсан 99.8 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад асуудын хэсгийг мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд Аудитын олон улсын стандартын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансы код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	5,942,888,324.41	5,763,671,068.45
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4,098,792,142.48	3,723,913,898.27
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	3,060,960.59	1,231,798.79
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	4,095,731,181.89	3,722,682,099.48
31213	Арилжааны банк дахь харилцах	2,886,661,749.06	2,765,979,647.18
31220	Гадаад валют	1,209,069,432.83	956,702,452.30
33	АВЛАГА	618,166,275.65	847,456,564.80
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	535,988,773.82	828,059,379.02
33500	Бусад авлага	82,177,501.83	19,397,185.78
33510	Байгууллагаас авах авлага	65,026,790.62	16,756,925.29
33520	Хувь хүмүүсээс авах авлага	17,150,711.21	2,640,260.49
34	УРЬДЧИЛГАА	1,945,109.37	7,256,166.89
34710	Урьдчилгаа тооцоо	1,945,109.37	7,256,166.89
34714	Томилолтын урьдчилгаа	1,945,109.37	7,256,166.89
35	БАРАА МАТЕРИАЛ	1,223,984,796.91	1,185,044,438.49
35100	Түүхий эд материал	173,706,211.70	215,199,299.20
35110	Тусгай зориулалттай материал	173,706,211.70	215,199,299.20
35400	Хангамжийн материал	1,050,278,585.21	969,845,139.29
35410	Бичиг хэргийн материал	15,158,174.47	17,188,120.00
35420	Аж ахуйн материал	195,385,395.96	191,606,867.83
35470	Бусад хангамжийн материал	839,735,014.78	761,050,151.46
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	10,534,526,492.12	10,293,123,480.81
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	10,534,526,492.12	10,293,123,480.81
39200	Биет хөрөнгө	9,791,193,992.16	9,548,431,814.21
39201	Барилга, байгууламж, орон сууц	9,635,559,751.25	9,635,559,751.25
39202	Хуримтлагдсан элэгдэл	(2,387,603,491.14)	(2,790,926,425.94)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	101,550,000.00	83,833,333.33
39204	Хуримтлагдсан элэгдэл	(101,550,000.00)	(28,208,333.33)
39205	Машинтоногтөхөөрөмж (компьютер)	2,502,921,312.86	2,491,862,054.16
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,435,185,900.24)	(1,361,817,134.99)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,257,449,939.43	1,274,805,563.85
39208	Хуримтлагдсан элэгдэл	(815,582,018.50)	(755,020,140.96)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	2,718,900.00	2,718,900.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	406,866,712.22	384,150,125.54
39215	Хуримтлагдсан элэгдэл	(235,937,627.70)	(223,757,483.23)
39217	Ном	859,986,413.98	835,231,604.53
39300	Биет бус хөрөнгө	743,332,499.96	744,691,666.60
39301	Програм хангамж	79,655,000.00	97,945,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(40,117,500.04)	(57,048,333.40)
39303	Бусад биет бус хөрөнгө	703,795,000.00	703,795,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	16,477,414,816.53	16,056,794,549.26
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,037,835,469.72	2,318,554,914.69
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,037,835,469.72	2,318,554,914.69
41300	Өглөг	37,325,171.64	42,784,312.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	28,237,774.71	3,778,171.52
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	5,375,081.93	5,190,050.00
41360	Бусад өглөг	3,712,315.00	33,816,090.48
41361	Байгууллагад төлөх өглөг	1,687,608.00	28,970,700.99
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	2,024,707.00	4,845,389.49

Соёл, урлагийн их сургуулийн 2025 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

41400	Урьдчилж орсон орлого	2,000,510,298.08	2,275,770,602.69
41440	Бусад урьдчилж орсон орлого	2,000,510,298.08	2,275,770,602.69
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	14,439,579,346.81	13,738,239,634.57
51	Засгийн газрын хувь оролцоо	14,439,579,346.81	13,738,239,634.57
51100	Засгийн газрын оруулсан капитал	4,872,800,270.44	4,831,934,429.24
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	4,872,800,270.44	4,831,934,429.24
51200	Хуримтлагдсан үр дүн	3,957,394,790.05	3,296,920,919.01
51210	Өмнөх үеийн үр дүн	4,599,828,929.16	3,797,169,038.30
51220	Тайлант үеийн үр дүн	(642,434,139.11)	(500,248,119.29)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,609,384,286.32	5,609,384,286.32
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	16,477,414,816.53	16,056,794,549.26

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	13,890,895,705.54	14,437,331,811.04
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,503,579,653.94	14,437,331,811.04
120	Нийтлэг татварын бус орлого	13,503,579,653.94	14,437,331,811.04
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	13,102,794,508.94	13,997,486,938.20
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,849,541,040.06	12,945,014,245.93
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,253,253,468.88	1,052,472,692.27
120009	Бусад орлого	-	439,844,872.84
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	400,785,145.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	387,316,051.60	439,844,872.84
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	387,316,051.60	214,388,344.84
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	158,488,482.00	214,388,344.84
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	228,827,569.60	225,456,528.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	14,339,827,150.02	15,663,482,348.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	14,339,827,150.02	15,663,482,348.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	14,150,244,357.02	15,418,233,188.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,653,223,481.23	10,133,310,930.27
210101	Үндсэн цалин	8,089,372,355.42	9,377,923,721.48
210105	Гэрээт ажлын хөлс	563,851,125.81	755,387,208.79
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,016,268,712.94	1,123,890,068.79
210201	Тэтгэврийн даатгалын зардал	722,430,993.27	789,146,612.31
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	81,150,251.56	92,012,335.83
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	40,918,328.18	45,994,450.03
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	28,927,010.02	32,759,436.34
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	142,842,129.91	163,977,234.28
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	293,115,999.12	358,895,633.79
210301	Гэрэл, цахилгаан	121,973,067.88	192,922,700.95
210302	Түлш, халаалт	121,376,162.69	111,845,006.89

Соёл, урлагийн их сургуулийн 2025 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

210303	Цэвэр, бохир ус	48,012,164.40	51,933,260.39
210304	Байрны түрээс	1,754,604.15	2,194,665.56
2104	Хангамж, бараа материалын зардал	464,450,694.91	337,597,363.32
210401	Бичиг хэрэг	59,526,498.36	50,662,952.17
210402	Тээвэр, шатахуун	7,907,185.70	7,960,185.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	116,010,889.64	112,037,555.33
210404	Ном, хэвлэл	103,489,032.28	69,894,073.80
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	107,956,036.83	97,042,597.02
210408	Бараа материал акталсны зардал	69,561,052.10	-
2105	Нормативт зардал	3,919,308.00	5,011,572.00
210502	Хоол, хүнс	3,919,308.00	5,011,572.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	446,615,310.00	262,474,158.00
210604	Урсгал засвар	446,615,310.00	262,474,158.00
2107	Томилолт, зочны зардал	266,606,209.31	239,092,418.55
210701	Гадаад албан томилолт	229,392,474.44	210,011,492.52
210702	Дотоод албан томилолт	13,229,117.84	9,511,450.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	23,984,617.03	19,569,476.03
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	275,231,214.33	326,670,115.97
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	275,231,214.33	326,670,115.97
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,730,813,427.18	2,631,290,927.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	925,176,321.26	888,595,457.94
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	558,657,819.54	558,090,232.44
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,246,979,286.38	1,184,605,237.26
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	189,582,793.00	245,249,160.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	189,582,793.00	245,249,160.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	189,582,793.00	245,249,160.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(448,931,444.48)	(1,226,150,537.29)
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	25,088,169.73	793,140,041.96
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	25,088,169.73	99,453,633.76
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	-	693,686,408.20
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	218,590,864.36	67,237,623.96
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	4,182,601.31	-
225002	Найдваргүй авлагын алдагдал	173,004,591.92	-
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	41,403,671.13	67,237,623.96
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(193,502,694.63)	725,902,418.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	(642,434,139.11)	(500,248,119.29)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,872,800,270.44	5,612,259,286.32	4,596,953,929.16	15,082,013,485.92
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	2,875,000.00	2,875,000.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,872,800,270.44	5,612,259,286.32	4,599,828,929.16	15,084,888,485.92
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	(2,875,000.00)	-	(2,875,000.00)
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(642,434,139.11)	(642,434,139.11)
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,872,800,270.44	5,609,384,286.32	3,957,394,790.05	14,439,579,346.81
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(40,865,841.20)	-	(160,225,751.75)	(201,091,592.95)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,831,934,429.24	5,609,384,286.32	3,797,169,038.30	14,238,487,753.86
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(500,248,119.29)	(500,248,119.29)
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,831,934,429.24	5,609,384,286.32	3,296,920,919.01	13,738,239,634.57

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	13,475,375,008.88	14,464,136,558.44
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,623,327,606.28	14,464,136,558.44
120	Нийтлэг татварын бус орлого	12,623,327,606.28	14,464,136,558.44
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,623,327,606.28	13,676,453,329.10
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,366,575,815.73	12,559,104,326.92
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,256,751,790.55	1,117,349,002.18
120009	Бусад орлого	-	787,683,229.34
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	852,047,402.60	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	852,047,402.60	-
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	623,219,833.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	228,827,569.60	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	13,054,276,087.34	14,569,332,146.14
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,054,276,087.34	14,569,332,146.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,877,619,181.84	14,276,334,007.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,590,787,448.93	10,073,427,379.74
210101	Үндсэн цалин	8,007,383,908.14	9,252,333,566.87
210105	Гэрээт ажлын хөлс	583,403,540.79	821,093,812.87
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,018,242,390.08	1,082,499,092.47
210201	Тэтгэврийн даатгалын зардал	738,027,525.11	774,372,933.99
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	77,267,514.09	90,796,014.71
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	38,997,732.53	40,992,069.25
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	27,433,060.49	29,179,318.96
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	136,516,557.86	147,158,755.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	293,620,380.16	359,080,665.72
210301	Гэрэл, цахилгаан	121,973,067.88	192,922,700.95
210302	Түлш, халаалт	121,880,543.73	112,030,038.82
210303	Цэвэр, бохир ус	48,012,164.40	51,933,260.39
210304	Байрны түрээс	1,754,604.15	2,194,665.56
2104	Хангамж, бараа материалын зардал	440,631,545.09	409,146,913.98
210401	Бичиг хэрэг	52,701,544.00	57,735,904.90
210402	Тээвэр, шатахуун	5,883,757.75	7,062,513.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	115,831,344.04	111,870,529.83
210404	Ном, хэвлэл	127,757,931.87	118,420,648.70
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	138,456,967.43	114,057,317.55
2105	Нормативт зардал	4,143,481.00	4,421,002.00
210502	Хоол, хүнс	4,143,481.00	4,421,002.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	450,123,276.00	274,708,133.00
210604	Урсгал засвар	450,123,276.00	274,708,133.00
2107	Томилолт, зочны зардал	265,759,006.81	244,368,425.17
210701	Гадаад албан томилолт	235,920,719.94	214,987,824.14
210702	Дотоод албан томилолт	8,733,242.84	9,847,850.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	21,105,044.03	19,532,751.03
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	262,555,535.76	316,308,935.97

Соёл, урлагийн их сургуулийн 2025 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	262,555,535.76	316,308,935.97
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,551,756,118.01	1,512,373,459.37
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	973,194,133.97	893,627,582.08
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	578,561,984.04	618,745,877.29
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	176,656,905.50	244,229,160.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	176,656,905.50	244,229,160.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	176,656,905.50	244,229,160.00
	Төсвийн захирагч хооронд хийсэн санхүүжилт		48,768,978.71
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	421,098,921.54	(105,195,587.70)
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	430,552,047.00	333,382,990.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	430,552,047.00	333,382,990.00
2200	Дотоод эх үүсвэрээр	430,552,047.00	333,382,990.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	430,552,047.00	333,382,990.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(430,552,047.00)	(333,382,990.00)
14	Бусад эх үүсвэр	20,186,128.69	92,068,841.39
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	20,186,128.69	92,068,841.39
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	25,619,117.37	28,368,507.91
250001	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	25,619,117.37	28,368,507.91
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(5,432,988.68)	63,700,333.48
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(14,886,114.14)	(374,878,244.21)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,113,678,256.62	4,098,792,142.48
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,098,792,142.48	3,723,913,898.27

Соёл, урлагийн их сургуулийн 2025 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	ҮЗҮҮЛЭЛТ	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	16,923,817,744.76	14,527,836,891.93	2,395,980,852.83	85.8
1310	Улсын төсвөөс санхүүжих	455,523,786.52	25,000,000.00	430,523,786.52	5.5
13100101	Улсын төсвөөс санхүүжих	455,523,786.52	-	455,523,786.52	
131002	ШУТ сангийн санхүүжилт	-	25,000,000.00	(25,000,000.00)	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	211,005,935.30	225,456,528.00	(14,450,592.70)	106.8
132001	Орон нутгийн төсвөөс	211,005,935.30	225,456,528.00	(14,450,592.70)	106.8
1310	Боловсролын зээлийн сангийн санхүүжилт	105,156,000.00	537,226,701.34	(432,070,701.34)	510.9
13100601	БЗС Сургалтын төлбөрийн санхүүжилт	-	396,158,301.34	(396,158,301.34)	
13100603	ЗГГ-ээр суралцагчийн тэтгэлэг	105,156,000.00	141,068,400.00	(35,912,400.00)	134.2
12	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	16,152,132,022.94	13,676,453,329.10	2,475,678,693.84	84.7
120004	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,987,764,600.00	12,559,104,326.92	428,660,273.08	96.7
1200041	Сургалтын төлбөрийн орлого	12,987,764,600.00	12,559,104,326.92	428,660,273.08	96.7
120010	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	703,231,790.74	849,295,763.03	(146,063,972.29)	120.8
120004201	Төсөл хөтөлбөрийн орлого	334,590,523.00	268,053,239.15	66,537,283.85	80.1
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	2,126,545,109.20		2,126,545,109.20	-
	Гадаад валютын ханшийн зөрүүний олз		63,700,333.48	63,700,333.48	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	16,923,817,744.76	14,853,946,157.43	2,069,871,587.33	87.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	16,923,817,744.76	14,853,946,157.43	2,069,871,587.33	87.8
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	16,684,665,744.76	14,609,716,997.43	2,074,948,747.33	87.6
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	10,501,875,210.60	10,073,427,379.74	428,447,830.86	95.9
210101	Үндсэн цалин	9,494,194,159.00	9,252,333,566.87	241,860,592.13	97.5
210105	Гэрээт ажлын цалин	1,007,681,051.60	821,093,812.87	186,587,238.73	81.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,312,734,401.26	1,082,499,092.47	230,235,308.79	82.5
210201	Тэтгэврийн даатгал	892,659,392.90	774,372,933.99	118,286,458.91	86.7
210202	Тэтгэмжийн даатгал	105,018,752.11	90,796,014.71	14,222,737.40	86.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	61,803,226.37	40,992,069.25	20,811,157.12	66.3
210204	Ажилгүйдлийн даатгал	43,215,525.70	29,179,318.96	14,036,206.74	67.5
210205	Эрүүл мэндийн даатгал	210,037,504.18	147,158,755.56	62,878,748.62	70.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	457,923,786.54	359,080,665.72	98,843,120.82	78.4
210301	Гэрэл, цахилгаан	169,168,805.54	192,922,700.95	(23,753,895.41)	114.0
210302	Түлш, халаалт	194,243,981.00	112,030,038.82	82,213,942.18	57.7
210303	Цэвэр, бохир ус	92,111,000.00	51,933,260.39	40,177,739.61	56.4
210303	Байр ашиглалтын зардал /түрээс/	2,400,000.00	2,194,665.56	205,334.44	91.4
2104	Хангамж, бараа материалын зардал	607,842,250.00	409,146,913.98	198,695,336.02	67.3
210401	Бичиг хэрэг	66,109,250.00	57,735,904.90	8,373,345.10	87.3
210402	Тээвэр, шатахуун	12,725,700.00	7,062,513.00	5,663,187.00	55.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	134,924,600.00	111,870,529.83	23,054,070.17	82.9
210404	Ном, хэвлэл	214,802,000.00	118,420,648.70	96,381,351.30	55.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, зүйлс	76,945,000.00	29,166,920.00	47,778,080.00	37.9
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	102,335,700.00	84,890,397.55	17,445,302.45	83.0
2105	Нормативт зардал	12,783,540.00	4,421,002.00	8,362,538.00	34.6
210501	Хоол, хүнс	12,783,540.00	4,421,002.00	8,362,538.00	34.6
210502	Эд хогшил, урсгал засварын зардал	1,212,897,100.00	608,091,123.00	604,805,977.00	50.1
2106	Үндсэн хөрөнгө худалдан авах зардал	678,920,800.00	333,382,990.00	345,537,810.00	49.1
21060301	Тавилга эд хогшил худалдан авах зардал	147,260,000.00	95,185,760.00	52,074,240.00	64.6
21060302	Машин тоног төхөөрөмж худалдан авах зардал	387,710,800.00	199,432,200.00	188,278,600.00	51.4
21060303	Ном худалдан авах зардал	63,500,000.00	19,425,030.00	44,074,970.00	30.6
21060304	Биет бус хөрөнгө худалдан зардал	80,450,000.00	19,340,000.00	61,110,000.00	24.0

Соёл, урлагийн их сургуулийн 2025 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

210604	Урсгал засвар	533,976,300.00	274,708,133.00	259,268,167.00	51.4
2107	Томилолт, зочны зардал	328,517,430.00	244,368,425.17	84,149,004.83	74.4
210701	Гадаад албан томилолт	273,664,430.00	214,987,824.14	58,676,605.86	78.6
210702	Дотоод албан томилолт	26,598,000.00	9,847,850.00	16,750,150.00	37.0
210703	Гадаад зочны зардал	28,255,000.00	19,532,751.03	8,722,248.97	69.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	343,940,595.36	325,238,935.97	18,701,659.39	94.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	343,940,595.36	325,238,935.97	18,701,659.39	94.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,906,151,431.00	1,503,443,459.37	402,707,971.63	78.9
210902	Хичээл дадлагын зардал	729,310,200.00	618,745,877.29	110,564,322.71	84.8
210904	Эрдэм шинжилгээний зардал	179,302,000.00	118,176,338.01	61,125,661.99	65.9
210905	Оюутны үйлчилгээний зардал	327,015,000.00	230,338,156.64	96,676,843.36	70.4
210906	Мэргэжил дээшлүүлэх зардал	56,320,000.00	25,521,070.00	30,798,930.00	45.3
210908	Биеийн тамирын уралдаан тэмцээний зардал	38,808,000.00	8,737,900.00	30,070,100.00	22.5
210909	Зар сурталчилгааны зардал	37,982,500.00	11,461,158.00	26,521,342.00	30.2
210910	Захиргааны зардал	21,060,000.00	12,950,119.00	8,109,881.00	61.5
210911	Төвлөрсөн арга хэмжээний зардал	69,110,000.00	25,999,717.30	43,110,282.70	37.6
210912	Төсөл хөтөлбөрийн зардал	447,243,731.00	451,513,123.13	(4,269,392.13)	101.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	239,152,000.00	244,229,160.00	(5,077,160.00)	102.1
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшуулал	133,996,000.00	121,807,560.00	12,188,440.00	90.9
213210	ЗГГ-ээр суралцагчийн тэтгэлэг	105,156,000.00	122,421,600.00	(17,265,600.00)	116.4
	СУСХ-ийн мөнгөн хөрөнгийн эхний үдэгдэл		48,768,978.71	(48,768,978.71)	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	4,098,792,142.48		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	3,723,913,898.27		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Соёл урлагийн их сургууль нь эрхэм зорилгоо “Соёл урлагийн мэргэжлээр авьяаслаг бүтээлч, шилдэг уран бүтээлч, мэргэжилтнийг бэлтгэх, төрөөс соёл урлагийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц судалгааны ажлыг явуулах, Монгол үндэсний соёл урлагийн гол уурхай болно” гэж тодорхойлсон байна.

Соёл урлагийн их сургууль нь үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Бакалавр, магистр, докторын сургалт, ахлах сургууль, гүнзгийрүүлсэн болон нарийн мэргэжлийн, бэлтгэл, мөн мэргэжил дээшлүүлэх сургалтыг явуулах;
- Соёл урлагийн чиглэлээр улсын хэмжээний, салбарын урт, богино хугацааны хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцох, зөвлөгөө өгөх;
- Зорилтот суурь болон хэрэглээний судалгаа хийх, шинэ мэдлэг бүтээж, сургалт, судалгааны эргэлтэд оруулах, бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;
- Гэрээт, захиалгат, төлөвлөгөөт сэдэв, асуудлаар судалгаа, уран бүтээл, туршилт зохион байгуулах үйл ажиллагаа эрхлэх;
- Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн сургалт, судалгааны хөтөлбөр модулиудыг боловсруулан хэрэгжүүлэх, гадаад харилцаа, улс хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- Үндэсний болон олон улсын хэмжээний консорциум, холбоо, нэгдэл, парк, кластерт нэгдэн орох;
- Оюуны өмчийн баталгаажуулах, эзэмших, патент-лицензийн үйл ажиллагаа эрхлэх;
- Зөвлөх үйлчилгээ, уран бүтээл зуучлалын үйлчилгээ эрхлэх;
- Соёл урлагийн их сургуулийн үйл ажиллагааг сурталчлах, үндэсний болон олон улсын хэмжээний наадам, үзэсгэлэн, форум, тэмцээн, соёл урлагийн үйл ажиллагаанд оролцох, зохион байгуулах.

Тайлант хугацааны онцлог ажлууд:

- Засгийн газрын 2024 оны 207 дугаар тогтоолын дагуу Соёл, урлаг судлалын хүрээлэн Соёл, урлагийн их сургуулийн бүтцээс гарч, улсын төсвөөс санхүүждэг болсон байна.
- Удирдах зөвлөлийн 2025 оны 4 дүгээр тогтоолоор сургалтын болон дотуур байрны төлбөрийн хэмжээг шинэчлэн баталсан;
- Соёл, урлагийн их сургууль 4 дэх удаагаа магадлан итгэмжлэгдсэн.
- Бакалаврын 6 хөтөлбөр Магадлан итгэмжлэгдсэн;
- Магистрын 1 хөтөлбөрийн магадлан итгэмжлэгдсэн.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Соёл урлагийн их сургуулийг Шинжлэх ухаан боловсролын сайдын 1994 оны 174 тоот тушаалыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах” гэсэн заалттай нийцэж байна.

Сургуулийн удирдлагыг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны А/576 дугаар тушаалаар батласан “Дээд боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөлийн дүрэм”, Дээд боловсролын тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан чиг үүргийн хүрээнд Соёл урлагийн их сургуулийн Удирдах зөвлөлийн 2025 оны 08 тоот тогтоолоор томилсон байна.

Тус сургууль нь Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Соёл, урлагийн их сургуулийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд тайлант онд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 215 дугаар тогтоолоор “Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх, зээлийг эргэн төлүүлэх журам” шинэчлэн батлагдсан;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсон;
- Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 214 дүгээр тогтоолоор Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам батлагдаж, 2025 оноос даган мөрдөж байна;
- Засгийн газрын 2025 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн 158 дугаар тогтоолоор 2026 оныг "боловсролыг дэмжих жил" болгон зарласан;
- Боловсролын сайдын 2025 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн А/465 дугаар тушаалаар Боловсролын цахим мэдээллийн сан бүрдүүлэх, ажиллуулах журам шинэчлэн батлагдсан.

Соёл, урлагийн их сургуулийн Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, үр нөлөөтэй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Соёл, урлагийн их сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус сургууль нь Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/22 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж ажилладаг бөгөөд уг баримт бичиг нь

Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн боловч 2021 оноос хойш өөрчлөлт ороогүй.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Соёл, урлагийн их сургуулийн 2025 оны санхүүгийн тайланг УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Соёл, урлагийн их сургууль Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тайлант хугацаанд өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 420.6 сая төгрөгөөр буюу 2.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	4,098,792.1	3,723,913.9	(374,878.2)
Авлага	618,166.3	847,456.6	229,290.3
Урьдчилгаа	1,945.1	7,256.2	5,311.1
Бараа материал	1,223,984.8	1,185,044.4	(38,940.4)
Үндсэн хөрөнгө	10,534,526.5	10,293,123.5	(241,403.0)
Нийт хөрөнгө	16,477,414.8	16,056,794.5	(420,620.3)
Өр төлбөр	2,037,835.5	2,318,554.9	280,719.4
Эздийн өмч	14,439,579.3	13,738,239.6	(701,339.7)
Нийт өр төлбөр ба эздийн өмчийн дүн	16,477,414.8	16,056,794.5	(420,620.3)

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, эздийн өмчийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 374.9 сая төгрөгөөр буурсан нь арилжааны банкууд дахь данснуудын зарцуулалтаас шалтгаалсан;
- Авлага 229.3 сая төгрөгөөр өссөн байна. Нийт авлагын 97.7 хувийг сургалтын төлбөрийн авлага эзэлж байна. Авлагын өсөлт нь Боловсролын зээлийн сангаас авах 381.3 сая төгрөгийн авлагатай голлон холбоотой;
- Бараа материал дансны үлдэгдэл 38.9 сая төгрөгөөр буурсан нь батлагдсан төсвийн хүрээнд өөрийн хөрөнгөөр 694.3 сая төгрөгийн бараа материал худалдан авч, хандиваар 21.7 сая төгрөгийн бараа материал хүлээн авч, Үйл ажиллагаанд 622.9 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, бүтцийн сургуулиудын захирлуудын тушаалаар 35.7 сая төгрөгийн бараа материалыг акталж, 20.1 сая төгрөгийн бараа материалыг худалдан борлуулж, Засгийн газрын 2024 оны 207 дугаар тогтоолын дагуу Соёл, урлаг судлалын хүрээлэн Соёл, урлагийн их сургуулийн бүтцээс гарсанаар 30.9 сая төгрөгийн бараа материалыг данснаас хасч шилжүүлэн, 7.2 сая төгрөгийн бараа материалыг тусгай зориулалтын материал данснаас бусад хангамжийн материал данс руу, 45.3 сая төгрөгийн бараа материалыг бусад хангамжийн материал данснаас үндсэн хөрөнгийн данс руу ТӨБЗГ-ын 2025 оны А1/2024 тоот зөвшөөрлийн дагуу шилжүүлэн бүртгэсэнтэй холбоотой;
- Үндсэн хөрөнгө 241.4 сая төгрөгөөр буурсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- Батлагдсан төсвийн хүрээнд ТӨБЗГ-ын 2025 оны 83 дугаар тогтоолын дагуу өөрийн хөрөнгөөр 333.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, хандиваар олж бэлтгэсэн хөрөнгө 41.8 сая төгрөгийн хөрөнгө хүлээн авч, 45.3 сая төгрөгийн бараа материалыг бусад хангамжийн материал данснаас үндсэн хөрөнгийн данс руу ТӨБЗГ-ын 2025 оны А1/2024 тоот зөвшөөрлийн шилжүүлэн авч, ТӨБЗГ-ын 2025 оны 538 дугаар тогтоолын дагуу 630.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн бүртгэсэн;
- ТӨБЗГ-ын 2025 оны 561 дүгээр тогтоолын дагуу 107.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, ТӨБЗГ-ын 2025 оны 538 дүгээр тогтоолын дагуу 841.6 сая төгрөгийн дансны үнэтэй, элэгдлээ бүрэн нөхсөн, үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунган, үнийг шинэчилсэн, үүнийг үндсэн хөрөнгийн тодруулгын бусад хэсэгт бууруулан бүртгэж, Засгийн газрын 2024 оны 207 дугаар тогтоолын дагуу Соёл урлаг судлалын хүрээлэн нь СУИС-ийн бүтцээс гарсан тул 142.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хасч, Соёл урлаг судлалын хүрээлэн рүү шилжүүлж, 1,184.6 сая төгрөгийн элэгдлийн зардал байгуулснаас шалтгаалсан;
- Өглөг дансны үлдэгдэл 280.7 сая төгрөгөөр өссөн нь урьдчилж орсон орлого 275.3 сая төгрөгөөр, байгууллагад төлөх өглөг 27.2 сая төгрөгөөр, хувь хүмүүст төлөх өглөг 2.8 сая төгрөгөөр тус тус өссөн, ажиллагсадтай холбогдсон өглөг 24.4 сая төгрөгөөр, түлш халаалтын өглөг 0.2 сая төгрөгөөр буурсантай холбоотой байна. Нийт өр төлбөрийн 98.1 хувь буюу 2,275.8 сая төгрөг нь оюутны сургалтын төлбөрийн урьдчилж орсон орлого эзэлж байна.
- Эздийн өмч 701.3 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.
- Биет бус хөрөнгийн дансанд 97.9 сая төгрөгийн программ хангамж бүртгэлтэй байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

3.5.1 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3, Дээд боловсролын тухай хуулийн 11 дүгээр зүйл, Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 12.1-д заасны дагуу Соёл, урлагийн их сургуулийн захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө /техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Соёл, урлагийн их сургуулийн удирдах зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 05 дугаар тогтоолоор тайлант оны төсөвт зардал, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 15,712.9 сая төгрөгөөр, Ерөнхий боловсролын ахлах сургуулийн зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 18-ны 03 дугаар тогтоолоор 1,210.8 сая төгрөгөөр, нийт 16,923.8 сая төгрөгөөр тооцож, төлбөрт үйлчилгээний орлогоос 12,987.8 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 211.0 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 1,037.8 сая төгрөг, улсын төсвөөс 560.7 сая төгрөг, урьд оны үлдэгдлээс 2,126.5 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр нийт 14,527.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 4,853.9 сая төгрөгийг зарцуулж, мөнгөн хөрөнгийн 4,098.8 сая төгрөгийн үлдэгдлээс Засгийн газрын 2024

оны 207 дугаар тогтоолын дагуу Соёл, урлаг судлалын хүрээлэн Соёл, урлагийн их сургуулийн бүтцээс гарснаар 48.8 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө хасагдаж, 3,723.9 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Нийт орлогын гүйцэтгэл 14,527.8 сая төгрөг болж, төлөвлөгөөнөөс 2,395.9 сая төгрөг буюу 14.2 хувиар дутуу биелэсэн нь:

- Үндсэн үйл ажиллагааны орлого буюу сургалтын төлбөрийн орлогын гүйцэтгэл 96.7 хувьтай байгаа нь элсэлтийн тоо, оюутны хичээл сонголт, сургалтын төлбөрийн төлөлт төлөвлөсөн хэмжээнд хүрээгүйтэй;
- Дээд боловсролын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.3 дахь заалтыг үндэслэн хичээлийн байр, дотуур байрны тогтмол зардлын санхүүжилтийг улсын төсвөөс авахаар 455.5 сая төгрөгийг тусгасан боловч Засгийн газрын 2024 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 164 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын эзэмшиж, ашиглаж байгаа хөрөнгийн төрийн өмчийн тогтмол зардлыг санхүүжүүлэх журам”-ын шалгуурыг хангаагүй учир тус сургуулийн тогтмол зардлын санхүүжилт 2025 онд олгогдоогүйтэй;
- Урьд оны үлдэгдлээс 2,126.5 сая төгрөг зарцуулахаар төсөвлөсөн боловч зарцуулаагүйтэй холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэл 14,853.9 сая төгрөг болж, төлөвлөснөөс 2,069.9 сая төгрөг буюу 12.2 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 428.4 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 98.8 сая төгрөг, хангамж, бараа материалын зардал 198.7 сая төгрөг, урсгал засварын зардал 259.3 сая төгрөг, албан томилолт, зочны зардалд 84.1 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал 18.7 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 402.7 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан нь гол нөлөө үзүүлсэн байна.

Эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Судалгааны үр дүн: Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу аудитын явцад тус байгууллагаас дараах зардлын судалгааг авч, үр дүнг дүгнэлээ. Тухайлбал:

- Тайлант онд 453 орон тоо батлагдсанаас гүйцэтгэлээр 448 орон тоотойгоор ажилласан, орон тоог цомхотгоогүй байна.
- Соёл, урлагийн их сургуулийн ректорын 2014 оны Б/01 дугаар тушаалаар ажлын нэг өдөрт хоолны зардлыг үндсэн ажилтнуудад 4.0 мянган төгрөг, унааны зардлыг 1.0 мянган төгрөгөөр, тэтгэврээ тогтоолгоод ажиллаж буй ажилтнуудад ажлын нэг өдөрт хоолны зардлыг 2.5 мянган төгрөгөөр тогтоосон байна. Ерөнхий боловсролын ахлах сургуулийн захирлын 2025 оны 1 дугаар сарын 27-ны өдрийн Б/01 дугаар тушаалаар ажлын нэг өдөрт хоолны зардлыг үндсэн ажилтнуудад 8.5 мянган төгрөг, унааны зардлыг 1.0

мянган төгрөгөөр, тэтгэврээ тогтоолгоод ажиллаж буй ажилтнуудад ажлын нэг өдөрт хоолны зардлыг 5.0 мянган төгрөгөөр тогтоосон байна.

- Гадаад томилолт, арга хэмжээний зардалд 328.5 сая төгрөгийг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 243.4 сая төгрөг зарцуулсан байна.
- Сургалт, семинар, хурал, зөвлөгөөнд 119.2 сая төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 87.0 сая төгрөг зарцуулсан байна.
- Эрдэм шинжилгээ, сургалт, судалгаа, уран бүтээлтэй холбоотой мэдээ мэдээллийг "Өнөөдөр" сонины дугаараар дамжуулан иргэд олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, хүргэх ажлыг гүйцэтгүүлэхээр 8.0 сая төгрөг шилжүүлсэн байна.

3.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Соёл, урлагийн их сургуулийн 2025 оны төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг удирдах зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 05 дугаар тогтоолоор баталж, хэрэгжилтийг зохион байгуулан ажилласан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн нээлттэй тендерийн аргаар 4, харьцуулалтын аргаар 5, шууд худалдан авах аргаар 1, нийт дагуу 996.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10 төрлийн худалдан авалт хийхээр төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 6 гүйцэтгэгчтэй 448.6 сая төгрөгийн гэрээ байгуулан, гүйцэтгэлийг хангаж ажилласан байна.

Төсвийн хүндрэлээс шалтгаалан шалгаруулсан 2 гүйцэтгэгчтэй гэрээг байгуулалгүй, 2026 онд гүйцэтгүүлэхээр хойшлуулсан байна. Мөн дадлагын баазын цахилгааны засварын ажил, тавилга худалдан авах ажиллагааг хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Соёл, урлагийн их сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Соёл, урлагийн их сургууль түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Анализ старт аудит ХХК-ийн аудитор Ц.Саранцэцэг, аудиторын туслах Д.Энхцаг нар гүйцэтгэж, компанийн захирал Н.Энхтуяа анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Э.Бат-Эрдэнэ, аудитын менежер С.Нацагдорж, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Соёл, урлагийн их сургууль 2025 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 01/102 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайланг, суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 13,915.9 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 139.1 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн хуулийн дагуу зардал бууруулах, хэмнэх бодлого барьж зарим төлөвлөсөн ажлыг хамтын ажиллагааны хүрээнд болон дотоод нөөц боломжийн хүрээнд бага зардлаар зохион байгуулж, цахилгаан халаалтын температурыг ажлын бус цагаар багасгаж, тог цахилгааныг хэмнэх зохицуулалт хийж ажиллажээ. Үндсэн үйл ажиллагаатай шууд холбоотой, мэргэжлийн төрөлжсөн гадаад хэвлэл захиалгаас бусад төрлийн хэвлэл захиалга хийгээгүй, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа материал бэлтгэж нөөцлөөгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга,

нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 3 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Илрүүлэлт: Тайлант хугацаанд төсвийн шууд захирагчийн байршуулбал зохих 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 499.8 сая төгрөгийн 68 орлогын, цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 154.4 сая төгрөгийн 3 зарлагын, нийт 654.1 сая төгрөгийн 71 гүйлгээ мэдээлээгүй, 3 мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ:”, 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:” заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим системд тавих мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлээгүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Илрүүлэлт 1: Эмнэлгийн үйлчилгээ авах 44.4 сая төгрөгийн худалдан авалтын гэрээг дүгнээгүй, акт үйлдээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.1.4 “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, Иргэний хуулийн 343 дугаар зүйлийн 343.1 “Ажил гүйцэтгэх гэрээгээр ажил гүйцэтгэгч нь захиалагчийн буюу өөрийн материалаар гэрээнд заасан ажил гүйцэтгэх, захиалагч нь уг ажлын үр дүнг хүлээн авч, хэлэлцэн тохирсон хөлс төлөх үүргийг тус тус хүлээнэ” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах гэрээг дүгнэж, акт үйлдээгүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

Илрүүлэлт 2: Тайлант онд 39.9 сая төгрөгийн бараа материал худалдан авахдаа цахим дэлгүүрээс худалдан авахгүй, шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн хуулийн 14.4 “цахим дэлгүүрт байршсан барааг бусад этгээдээс худалдан авсан” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цахим дэлгүүрт байршсан барааг бусад этгээдээс худалдан авч байгаа зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа,

ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн болон бусад холбогдох хууль эрхийн актын хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланд аудит хийж, илрүүлсэн 923.4 сая төгрөгийн 16 зөрчлийг асуудлын бүртгэлээр танилцуулж, зөвлөмж өгсөн. Үүнээс 99.8 сая төгрөгийн зөрчилд өгсөн 2 зөвлөмжийн хэрэгжилт хангагдаагүй дараагийн аудитаар анхаарах асуудалд тусгасан болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 114.7 сая төгрөгийн 8 зөрчлөөс 79.2 сая төгрөгийн 1 албан шаардлага, 6 зөвлөмж хэрэгжиж, 5 жилээс дээш насжилттай сургалтын төлбөрийн 35.5 сая төгрөгийн авлага барагдуулах 1 зөвлөмж хэрэгжээгүй учир тайлант оны зөрчилд оруулсан болно.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	1	-	1	-	100.0
Зөвлөмж	7	114,747.6	6	79,204.7	85.7
Нийт дүн	8	114,747.6	7	79,204.7	85.7

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг сайжруулахтай холбоотой дараах саналуудыг хүргүүлж байна. Үүнд:

- Журмын хоёрдугаар хавсралтаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягт болон Сангийн яамны finperform.mof.gov.mn сайт дахь маягт хоорондын зөрүүг арилгах.
- Журмын гуравдугаар хавсралтаар батлагдсан дансны жишиг жагсаалтыг дээрх Сангийн яамны шинэ сайттай уялдуулах.

Сургуулийн санхүүгийн тайланд бараа материалын дансанд бүртгэлтэй үндсэн хөрөнгийн шинж агуулсан хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 705.3 сая төгрөгийн 16 алдаа илэрснээс 684.2 сая төгрөгийн 12 алдааг залруулж, залруулагдаагүй 21.1 сая төгрөгийн алдааг давтан гаргахгүй ажиллах 4 зөвлөмж өгсөн. Үүнд:

Залруулга:

- Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 389.3 сая төгрөгөөр дутуу тооцсон;
- Түлш халаалтын 5.2 сая төгрөгийн зардлыг Бараа үйлчилгээний өглөг, Бараа материал худалдсаны, Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх, Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд буруу ангилан бүртгэсэн;
- Боловсролын зээлийн сангаас орж ирсэн гадаад оюутны замын зардлын 6.7 сая төгрөгийн санхүүжилтийг өглөгөөр бүртгэж дансны харьцаа буруу хийснээс Орлогын тайлангийн орлого дутуу тайлагнагдсан;
- Боловсролын зээлийн сангийн санхүүжилтийн 44.2 сая төгрөгийн орлогыг Сургалтын төлбөрийн орлого, Төлбөртэй үйлчилгээний авлагаар буруу ангилан бүртгэсэн;
- Эрдэм шинжилгээний зардлыг 0.06 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн;
- Гадаад валютын ханшийн зөрүүний 0.007 сая төгрөгийн олзыг Төлбөртэй үйлчилгээний авлагаар буруу ангилж бүртгэсэн;
- Үнэ төлбөргүй хүлээн авсан 19.3 сая төгрөгийн бараа материалыг туслах үйлчилгээний орлогоор буруу ангилж бүртгэсэн;
- Эрдэм шинжилгээний 195.7 сая төгрөгийн зардлыг үндсэн хөрөнгийн элэгдлийн зардалд ангилал зөрүүлж бүртгэсэн;
- Аж ахуйн материал худалдан авах болон хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх 4.3 сая төгрөгийн зардлыг Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардалд буруу ангилан бүртгэсэн;
- Туслах үйл ажиллагааны 0.1 сая төгрөгийн орлогыг үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны орлогоор ангилал зөрүүлж бүртгэсэн;
- Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх 0.6 сая төгрөгийн зардлыг мэргэжил дээшлүүлэх зардлаар буруу ангилан бүртгэсэн;
- Актласан 18.7 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан зэрэг нь УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга 1.27-т Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой гэсэн заалттай нийцээгүй байсныг залруулсан.

Залруулагдаагүй алдаа:

Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Үндсэн хөрөнгийн дансанд анхны өртөггүй 16 үндсэн хөрөнгө /ном/ бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1."Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална" 5.1.4 "Үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.3 "нягтлан бодогч нь холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Анхны өртөггүй 16 үндсэн хөрөнгийг /ном/ бодит зах зээлийн үнээр бүртгэх,

Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт 2: Зардлын дансдын журналыг хөөн шалгахад 16.0 сая төгрөгийн зардлыг тооцооны дансаар дамжуулаагүй зардалд шууд бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1. "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална" 5.1.4 Үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.3 "нягтлан бодогч нь холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажил гүйлгээг тооцооны дансаар дамжуулан бүртгэж байх.

Авлагын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт 3:

Жилийн эцсийн татварын тодорхойлолтоор авлагыг тулган шалгахад 0.9 сая төгрөгийн суутган татварын авлагыг санхүүгийн тайланд бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 14.4. "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ" 14.4.2. "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланд авлагыг бүрэн тусгаж байх.

Өглөгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт 4: Жилийн эцсийн татварын тодорхойлолтоор өглөгийг тулган шалгахад 4.2 сая төгрөгийн суутган татварын өглөгийг санхүүгийн тайланд бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 14.4 "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ" 14.4.2 "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Татварын өглөгийг санхүүгийн тайланд бүрэн тусгаж байх.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн санхүүгийн зөрчил

Аудитаар нийт 77.0 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 35.6 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 20.3 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж, залруулагдаагүй 21.1 сая төгрөгийн 4 алдаанд зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 77.0 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 139.1 сая төгрөгөөс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.2. Албан шаардлага

Илрүүлэлт 1:

Жилийн эцсийн санхүүгийн тайланд толилуулсан авлага, өглөгийн үлдэгдлээс 118.8 сая төгрөгийн авлага, 102.4 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцооны баримтын жагсаалтаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ” 14.4.2 “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, 14.4.3 “бүх өр төлбөр”, 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын НХМаягт-ТМ-3 маягтыг тооцооны баримтын жагсаалтын хамт хөтлөж хавсаргах” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлага, өглөгийн үлдэгдлийг батлагдсан маягтаар тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 2:

Сургалтын төлбөрийн насжилт өндөртэй 35.6 сая төгрөгийн авлагыг шийдвэрлэж, барагдуулах зөвлөмжийн хэрэгжилт 25.0 хувьтай, хангалтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.4 “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сургалтын төлбөрийн насжилт өндөртэй авлагыг шийдвэрлэж, жилд 25-аас доошгүй хувиар барагдуулах албан шаардлага хүргүүлэв.

5.3. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.3.1. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээг анхан шатны баримт руу хөөн шалгахад 20.3 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээний худалдан авалт нь төлбөрийн и-баримтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа, ажил үйлчилгээний худалдан авалтын төлбөрийн и-баримтыг бүрэн бүрдүүлж байх.

5.3.2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт 2: Жилийн эцсийн үндсэн хөрөнгийн бүртгэлд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 1,061.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үнэ, ашиглалтын хугацааг шинэчлэн тогтоолгоогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх", ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолын "Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох" журмын 7.1 "төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүсэлт гаргаж, үндсэн хөрөнгийн үнэ, ашиглалтын хугацааг шинэчлэн тогтоох.

Илрүүлэлт-3: Байгууллагын хөрөнгөөр 2018 онд 18.6 сая төгрөгөөр 2 өрөө орон сууц худалдан авч, бүртгэлд тусгасан. Тус байранд урилгаар ажиллаж байгаа гадаад багш амьдарч ашиглалтын зардлыг нь сургууль төлдөг боловч байрны ордер, гэрчилгээ нь хувь хүний нэр дээр байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12.2 "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ" 12.2.1 "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" 20 дугаар зүйлийн 20.2 "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ" 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйл. Тооллогын

комисс, түүний эрх, үүрэг 4 “Тооллогын комисс дараахь үүрэгтэй 4/ комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Сургуулийн дансанд бүртгэлтэй орон сууцны ордер, гэрчилгээг байгууллагын нэр дээр шилжүүлэх ажлыг зохион байгуулах

5.3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

Илрүүлэлт 4: Тус сургуулийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт Дансны нэгдсэн төлөвлөгөөг бүрэлдэхүүн сургууль бүр ижил мөрдөхгүй, Үндсэн хөрөнгөнд "Номын фонд", Бараа материалд "Хангамж /ном/ гэж байгаа боловч ямар шалгуураар үндсэн хөрөнгө, бараа материалд ангилах тухай тусгагдаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2 “аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сургуулийн үйл ажиллагааны онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчилж, санхүү бүртгэлдээ ашиглаж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Үндсэн хөрөнгийн элэгдлийг давтан тооцоолоход 389,278.8 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг дутуу тооцож бүртгэсэн байна.	1	389,279.8			1	389,279.8	1	389,279.8				
2	Түлш халаалтын 5,190.0 мянган төгрөгийн зардлыг Бараа үйлчилгээний өглөг, Бараа материал худалдсаны, Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх, Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд буруу ангилан бүртгэсэн байна.	1	5,190.0			1	5,190.0	1	5,190.0				
3	Боловсролын зээлийн сангаас орж ирсэн гадаад оюутны замын зардлын 6,663.2 мянган төгрөгийн санхүүжилтийг өглөгөөр бүртгэж дансны харьцаа буруу хийснээс Орлогын тайлангийн орлого дутуу тайлагнагдсан байна.	1	6,663.2			1	6,663.2	1	6,663.2				
4	Боловсролын зээлийн сангийн санхүүжилтийн 44,234.0 мянган төгрөгийн орлогыг Сургалтын төлбөрийн орлого, Төлбөртэй үйлчилгээний авлагаар буруу ангилан бүртгэсэн байна.	1	44,233.9			1	44,233.9	1	44,233.9				
5	Анхан шатны баримттай тулган шалгахад Эрдэм шинжилгээний зардлыг 62.7 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн байна.	1	62.7			1	62.7	1	62.7				
6	Гадаад валютын ханшийн зөрүүний олзыг Төлбөртэй үйлчилгээний авлагаар буруу ангилж бүртгэсэн.	1	7.1			1	7.1	1	7.1				

Соёл, урлагийн их сургуулийн 2025 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

7	Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалыг туслах үйлчилгээний орлогоор буруу ангилж бүртгэсэн.	1	19,285.0			1	19,285.0	1	19,285.0				
8	Орлогын дэлгэрэнгүй тайланд 195,745.4 мянган төгрөгийн эрдэм шинжилгээний зардлыг үндсэн хөрөнгийн элэгдлийн зардалд ангилал зөрүүлж бүртгэсэн байна.	1	195,745.4			1	195,745.4	1	195,745.4				
9	Аж ахуйн материал худалдан авах болон хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардалд буруу ангилан бүртгэсэн.	1	4,285.2			1	4,285.2	1	4,285.2				
10	Орлогын тайланд 105.0 мянган төгрөгийн туслах үйл ажиллагааны орлогыг үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны орлогоор ангилал зөрүүлж бүртгэсэн байна.	1	105.0			1	105.0	1	105.0				
11	Орлогын дэлгэрэнгүй тайланд 640.0 мянган төгрөгийн хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг мэргэжил дээшлүүлэх зардлаар буруу ангилан бүртгэсэн байна.	1	640.0			1	640.0	1	640.0				
12	Актласан бараа материалыг зарцуулсан гэж буруу бүртгэсэн.	1	18,723.9			1	18,723.9	1	18,723.9				
13	Үндсэн хөрөнгийн дансанд анхны өртөггүй 16 үндсэн хөрөнгө /ном/ бүртгэсэн байна.	1	-			1	-			1	-	1	-
14	Жилийн эцсийн татварын тодорхойлолтоор авлагыг тулган шалгахад 881.0 мянган төгрөгийн суутган татварын авлагыг санхүүгийн тайланд бүртгээгүй байна.	1	893.1	1	893.1					1	893.1	1	893.1
15	Жилийн эцсийн татварын тодорхойлолттой татварын өглөгийг тулган шалгахад 4,200.0 мянган төгрөгийн газрын татварын өглөгийг санхүүгийн тайланд бүртгээгүй.	1	4,200.0	1	4,200.0					1	4,200.0	1	4,200.0
16	Зардлын дансдын журналыг хөөн шалгахад 16,013.3 мянган төгрөгийн	1	16,013.3			1	16,013.3			1	16,013.3	1	16,013.3

Соёл, урлагийн их сургуулийн 2025 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

зардлыг дамжуулаагүй байна.	тооцооны зардалд шууд бүртгэсэн	дансаар бүртгэсэн												
Дүн			16	705,327.8	2	5,093.1	14	700,234.7	12	684,221.4	4	21,106.4	4	21,106.4

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтан	Тоо	Дүн
1	Жилийн эцсийн санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 1,061,355.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үнэ, ашиглалтын хугацааг шинэчлэн тогтоолгоогүй байна.	1	-					1	-				
2	Мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээг анхан шатны баримт руу хөөн шалгахад 20,254.3 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээний худалдан авалт нь төлбөрийн и-баримтгүй байна.	1	20,254.3					1	20,254.3				
3	Жилийн эцсийн санхүүгийн тайланд толилуулсан авлага, өглөгийн үлдэгдлээс 118.8 сая төгрөгийн авлага, 102.4 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцооны баримтын жагсаалтаар баталгаажуулаагүй байна	1	-			1	-						
4	НБББББ-т Дансны нэгдсэн төлөвлөгөөг бүрэлдэхүүн сургууль бүр ижил мөрдөхгүй, Үндсэн хөрөнгөнд "Номын фонд", Бараа материалд "Хангамж /ном/ гэж байгаа боловч ямар шалгуураар үндсэн хөрөнгө, бараа материалд ангилах тухай тусгагдаагүй байна. НБББББ-т 2022 оноос хойш нэмэлт, өөрчлөлт оруулаагүй байна.	1	-					1	-				
5	Байгууллагын хөрөнгөөр 2018 онд 18,580.5 мянган төгрөгөөр худалдан авсан байрны ордер, гэрчилгээ нь хувь хүний нэр дээр байна.	1	-					1	-				

Соёл, урлагийн их сургуулийн 2025 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

6	Сургалтын төлбөрийн насжилт өндөртэй 35.6 сая төгрөгийн авлагыг шийдвэрлэж, барагдуулах зөвлөмжийн хэрэгжилт 25.0 хувьтай, хангалтгүй байна.	1	35,642.9			1	35,642.9					
дүн		6	55,897.2			2	35,642.9	4	20,254.3			

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	тоо	дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн данстай холбоотой зөрчил									
1	Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 499,766.3 мянган төгрөгийн 68 орлогын гүйлгээ, 154,378.4 мянган төгрөгийн 3 зарлагын гүйлгээг мэдээлээгүй, 3 мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1	654,144.7					1	654,144.7
Дүн		1	654,144.7					1	654,144.7
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
1	Эмнэлгийн үйлчилгээ авах 44,365.6 мянган төгрөгийн худалдан авалтын гэрээг дүгнээгүй, акт үйлдээгүй байна.	1	44,365.6					1	44,365.6
2	Шууд гэрээ байгуулж 39,943.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авахдаа цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна.	1	39,943.5			1	39,943.5		
Дүн		2	84,309.1			1	39,943.5	1	44,365.6
Нийт дүн		3	738,453.8			1	39,943.5	2	698,510.3



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1040/А0150458

Улаанбаатар хот

САГ-2026/59/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Соёл урлагийн их сургуулийн 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 39,943,500.00 /гучин есөн сая есөн зуун дөчин гурван мянга таван зуун/ төгрөгийн бараа материал худалдан авахдаа цахим дэлгүүрээс худалдан авалгүй шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 "Энэ хуулийн 37.2.4-т тодорхойлсон захиалагч ерөнхий гэрээ байгуулсан бараа, үйлчилгээг энэ хуульд өөрөөр заагаагүй бол цахим дэлгүүрээс худалдан авна", Төрийн хэмнэлтийн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 "цахим дэлгүүрт байршсан барааг бусад этгээдээс худалдан авсан" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.9 "Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Цахим дэлгүүрээс худалдан авалт хийдэггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Соёл урлагийн их сургуулийн ректорын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ч.Бат-Эрдэнэ/, Санхүү, хөрөнгө оруулалтын албаны дарга /Б.Отгонжаргал/ нарт даалгав.

АНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АНАЛИЗ СТАРТ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Н.ЭНХТУЯА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1041/АД150458

Улаанбаатар хот

САГ-2026/59/НА -СТА -ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Соёл урлагийн их сургуулийн 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сургалтын төлбөрийн насжилт өндөртэй 35,642,919.76 /гучин таван сая зургаан зуун дөчин хоёр мянга есөн зуун арван есөн төгрөг далан зургаан мөнгө/ төгрөгийн авлагыг шийдвэрлэж, барагдуулаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" 4.2.1.10 "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол"-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Өмнөх аудитаар өгсөн сургалтын төлбөрийн насжилт өндөртэй авлагыг жилд 25-аас доошгүй хувиар барагдуулах, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Соёл урлагийн их сургуулийн ректорын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ч.Бат-Эрдэнэ/, Санхүү, хөрөнгө оруулалтын албаны дарга /Б.Отгонжаргал/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АНАЛИЗ СТАРТ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Н.ЭНХТУЯА



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-70.Docx

1526181266



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1042/A0150458

Улаанбаатар хот

САГ-2026/59/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Соёл урлагийн их сургуулийн 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Жилийн эцсийн санхүүгийн тайланд толилуулсан авлага, өглөгийн үлдэгдлээс 118,781,978.68 /нэг зуун арван найман сая долоон зуун наян нэгэн мянга есөн зуун далан найман төгрөг жаран найман мөнгө/ төгрөгийн авлага, 102,371,103.62 /нэг зуун хоёр сая гурван зуун далан нэгэн мянга нэг зуун гурван төгрөг жаран хоёр мөнгө/ төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцооны баримтын жагсаалтаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлац бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2. бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага, 14.4.3 бүх өр төлбөр", 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 3.Тооцооны үлдэгдлийн баталгаа: Харилцагч талуудын хооронд гарсан ажил гүйлгээг тодруулан тайлант үеийн эцэс дэх хоорондын тооцооны үлдэгдлийг баталгаажуулахдаа улирал, жилийн эцэст харилцагч талууд тооцооны үлдэгдлийн баталгааг үйлдэнэ. Шаардлагатай бол санхүүгийн тайлангийн дундуур хийж болно. Тооцооны үлдэгдлийн баталгааг тооцоо үүссэн данс тус бүрээр хөтлөнө. 2 байгууллагын тооцооны баримтыг тооцооны үлдэгдлийн баталгааны хавсралтад нэгтгэж гаргана" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.7 "Авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлага, өглөгийн үлдэгдлийг батлагдсан маягтаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Соёл урлагийн их сургуулийн ректорын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ч.Бат-Эрдэнэ/, Санхүү, хөрөнгө оруулалтын албаны дарга /Б.Отгонжаргал/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АНАЛИЗ СТАРТ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Н.ЭНХТУЯА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-70.Docx

1526181264